



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 27 өдөр

Дугаар #1460

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.д, 29.1.5.в, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулж буй ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжид хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулан бодит байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгч, тулгамдсан асуудлыг цаг алдалгүй шуурхай шийдвэрлэн, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2021 оны 11 дүгээр сард багтаан танилцуулахыг ажлын хэсэг (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100977

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны 09
дугаар сарын 17-ны өдрийн 1460 дугаар
захирамжийн хавсралт

ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн
хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын
харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга,
хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Ганбат (аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Хөрөнгө
оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хорооны гишүүн,
Арвайхээр сумын Засаг дарга)

Н.Хишигт (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын
Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

О.Төмөрчөдөр (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын
газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Энхсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал
жуулчлалын газрын Усны нөөц, ашиглалт, хамгаалалтын
асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ц.Гантулга (Онги-Таац сав газрын захиргааны Усны барилга байгууламж
хариуцсан мэргэжилтэн)

Холбогдох сумын Засаг дарга нар

